



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.07.04 № А-1/2890  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулгын хариу хүргүүлэх  
тухай**

Тус газраас зарласан “Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах смарт телевизор ерөнхий гэрээгээр худалдан авах” ТХААГ/20240502004 дугаартай төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад захиалагчаас ирүүлсэн дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
Тухайн тендерийн техникийн тодорхойлолт өргөн хэрэглээний зах зээл дээр RAM 4GB, ROM 32GB гэсэн үзүүлэлт үйлдвэрлэгддэггүй юм байна. Өргөн хэрэглээний зах зээл дээр дээр RAM 2GB, ROM 16GB түгээмэл үйлдвэрлэгдэж байгаа тул уг тендерт заасан үнийн дүнд дүйцэхүйц үзүүлэлтийг дахин нягталж өгнө үү.	Боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 2/2867 дугаартай албан бичгээр Ерөнхий боловсролын сургуулийн анги танхимд боловсрол сургалтын үйл ажиллагаанд нийцэх техникийн үзүүлэлт сайтай, эдэлгээ даахуйц, дундаж үнэтэй ухаалаг зурагтын техникийн тодорхойлолтыг зах зээлийн судалгаа хийсний үндсэн дээр боловсруулсан тухай албан мэдэгдэлийг ирүүлсэн байна. Иймд “Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах смарт телевизор ерөнхий гэрээгээр худалдан авах” ТХААГ/20240502004 дугаартай тендерийн смарт телевизорын техникийн тодорхойлолтыг RAM 4GB гэснийг 2GB, ROM 32GB гэснийг 16GB болгох хүсэлтийг хүлээж аваагүй болохыг мэдэгдье.
Манай компани Skyworth, Konka, JPE, Finlux, LG, Sharp брэндийн албан ёсны төлөөлөгч учраас нийт бүх брэндээрээ тендерт үнийн санал өгч болох эсэхийг тодруулж өгнө үү.	Тендерт оролцогч техникийн шаардлага хангасан аль ч брэндийн смарт телевизор санал болгож болно. Тухайн тендер шалгаруулатын ТШЗ-ны 13.1-д заасны дагуу хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрөхгүй болохыг анхаарна уу.

Тодруулагатай холбогдуулан Тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

1324027791

ТШЗ 24.1-д Тендер хүлээх авах эцсийн хугацаа: 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдөр 10.00 цагт.

Тендерийн нээлт хийх огноо цаг нь : 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдөр 10.10 цагт.

Хавсралтаар Боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 2/2867 дугаартай албан бичгийг хүргүүлэв.

Хавсралт:...хуудастай

ДАРГА  Ц.БАТЗУЛ

